

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Ц.Эрдэмбилэг
Ц.ЭРДЭМБИЛЭГ

ГҮЙЦЭТГЭГЧ:



Т. БААТАРСҮРЭН

Улсын Хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засвар
/ Улаанбаатар, Баянзүрх дүүрэг /
Дугаар : ЭМЯ/2021.XIX.2.3.12

2021 оны 07 дугаар сарын 09-ны өдөр

8269.

Улаанбаатар хот

Нэг талаас **Эрүүл мэндийн яам** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **“БАКО КОНСТРАКШН” ХХК** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, Барилгын тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Улсын Хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг /, (цаашид “ажил” гэх) 898,469,710 (Найман зуун ерэн найман сая дөрвөн зуун жаран есөн мянга долоон зуун арав) **төгрөг**, (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: 898,469,710.00 төгрөг
Зураг төсвийн зарлыг эхний санхүүжилтээс 32,035,071.00 төгрөг
4. Гүйцэтгэгч нь Улсын Хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засварын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 19-ны өдөр эхэлж, 2021 оны 11 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:


Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
Бусад шаардлагатай Тендерийн баримт бичиг
Гэрээний тусгай нөхцөл
Гэрээний ерөнхий нөхцөл
Ажил гүйцэтгэх хуваарь
Ажлын зураг төсөв

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
10. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол урьдчилан мэдэгдэж, харилцан тохиролцож бичгээр үйлдэж нэмэлт өөрчлөлт оруулна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭМЯ-ны ЭМСЭЗБХГ-ын

дарга  Д.Нарантуяа

ЭМЯ-ны Захиргаа, хуулийн хэлтсийн

дарга  Л.Дашравдан

ЭМЯ-ны ХОХ-ийн

дарга  Т.Хонгорзул


ЭМЯ-ны Захиргаа, хуулийн хэлтсийн
мэргэжилтэн  Д.Туяа

ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн  М.Гэрэлтуяа

Хаяг: Засгийн газрын VIII байр, Олимпийн
гудамж – 2, Сүхбаатар дүүрэг 14210,
Улаанбаатар хот

Утас: 51-263631, 51-263913

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Захирал

Т.БААТАРСҮРЭН

Ерөнхий
инженер

Ш.БОЛДБААТАР

Хаяг: УБ хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө Экспресс таур 8
давхар 809 тоот

Утас: 88116856

Майл : bakoconstructionllc@gmail.com

Регистрийн дугаар: 5254655

Улсын бүртгэлийн дугаар: 9011166107

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

**“УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 50 ОРТОЙ БАЙРНЫ ЗАСВАР
/УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ”-ЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, ДҮГНЭЛТ**

Тендер шалгаруулалтын дугаар: ЭМЯ/2021.XII.2.3.12

УЛААНБААТАР ХОТ

2021 ОН

1. ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/206 дугаар тушаалаар батлагдсан эрүүл мэндийн салбарын их засварын ажлын жагсаалтад тусгагдсан ЭМЯ/2021.ХИ.2.3.12 дугаартай “Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/-ын ажлын үнэлгээний хороо Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/52 дугаар тушаалаар байгуулагдсан.

Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/52 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь Тендерийн баримт бичгийг боловсруулж 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдөр нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, эрх бүхий тендерт оролцогчдоос цахим тендер ирүүлэхийг хүссэн.

2. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Сангийн сайдын 2012 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”-ийг ашиглан тендерийн баримт бичгийг боловсруулсан.

Тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид хууль гэх/” болон Сангийн сайдын 2012 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 03 дугаар хавсралтаар баталсан “Тендерийн үнэлгээний зааврын дагуу үнэлнэ.

3. ТЕНДЕР ЗАРЛАХ БА ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ

Тендерийн баримт бичгийг үнэлгээний хорооны хурлаар хэлэлцэж боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.

Тендерийн урилгыг болон тендерийн баримт бичгийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn, хуудсанд нийтэлсэн.

4. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОДРУУЛГА

Тендерт оролцохыг сонирхогчидод тодруулга нийтлээгүй болно.

5. ТЕНДЕРИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА БА ХААХ ӨДӨР

Тендер нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаа буюу 2021 оны 07 дугаар сарын 21-ны өдрийг дуустал хүчинтэй байна.

6. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙГ ИРҮҮЛЭХ БА НЭЭХ ӨДӨР

Урилгад заасны дагуу ЭМЯ/2021.ХИ.2.3.12 дугаартай “Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/-ын ажлын тендерийн нээлтийг товлосон хугацаанд буюу 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 15 цаг 15 минутад нээхэд 7 компани тендер иүүлсэн байна. Үүнд:

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн үнийн хөнгөлөлт	Тендерийн баталгааны дүн (Хугацаа)
1	“Бако Констракшн” ХХК	898,469,710.00	-	Худалдаа хөгжлийн банк 2021.08.18-ны өдрийг дуустал
2	“Зууны сод хийц” ХХК	898,617,070.00	-	Хаан банк 2021.09.01-ний өдрийг дуустал

3	“Их-Азар” ХХК	903,928,755.00	-	Хаан банк 2021.08.18-ны өдрийг дуустал
4	“Ирмүүнбар” ХХК	922,464,537.00	-	Худалдаа хөгжлийн банк 2021.08.18-ны өдрийг дуустал
5	“Тэргүүн констракшн” ХХК	934,223,767.00	-	Худалдаа хөгжлийн банк 2021.08.21-ний өдрийг дуустал
6	“Жи Ти Кэй Эс” ХХК	935,628,656.00	-	Худалдаа хөгжлийн банк 2021.08.20-ны өдрийг дуустал
7	“Акропол” ХХК	964,851,909.00	-	Хас банк 2021.08.20-ны өдрийг дуустал

Нээлтийн тэмдэглэлийг хавсаргав.

7. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тендерийг хянан үзэв.

7.1. Эрх бүхий эсэх

Хуулийн 14 дүгээр зүйл, тендерийн баримт бичиг, Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг болон Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх заарчилгааны 3 дугаар зүйлд тус тус заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан үзэв.

7.2. Гэрээг хэрэгжүүлэх чадварыг хангасан эсэх

Хуулийн 15, 16 дугаар зүйл, Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг болон Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх заарчилгааны 4, 5 дугаар зүйлд заасны дагуу гэрээ хэрэгжүүлэх чадвартай эсэхийг хянан үзэв.

7.3. Шаардлагад нийцэж буй эсэхийг магадлах

Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг болон болон Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх заарчилгааны 6, 10, 11, 16 дугаар зүйлд тус тус заасны дагуу шаардлагад нийцсэн эсэхийг магадлан үзэв.

7.4. Тендерийн баталгаа шаардлага хангасан эсэх

Хуулийн 20 дугаар зүйл болон Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасны дагуу тендерийн баталгаа ирүүлсэн эсэхийг хянан үзэв.

7.5. Үндсэн шаардлагыг хангасан эсэх

Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт заасан үндсэн шаардлагыг хангасан эсэх болон Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх заарчилгааны 16 дугаар зүйлд тус тус заасныг магадлав.

Хянан үзэх хүснэгтийг хавсаргав.

8. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ТЕНДЕР ИРҮҮЛСЭН ЭСЭХ

Дээрх шаардлагуудыг хянан үзэхэд “Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”-ын ажлыг хийж гүйцэтгэхээр нийт 7 компани санал ирүүлснээс “Бако Констракшн” ХХК-ийн тендер шаардлага хангасан болно.

1. “Зууны сод хийц” ХХК дараах шаардлагыг хангаагүй гэж үзэж татгалзлаа.

№	Хуулийн үндэслэл	Тендерийн шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Төрийн болон орон нутгийн өмчийн	-	“Зууны сод хийц” ХХК –ийн ирүүлсэн тендер нь шаардлагад нийцсэн

	хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3 дахь хэсэг		боловч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерт оролцогчдоос өндөр үнийн санал ирүүлсэн тул шаардлага хангахгүй.
--	--	--	---

2. “ИХ-АЗАР” ХХК дараах шаардлагыг хангаагүй гэж үзэж татгалзлаа.

№	Хуулийн үндэслэл	Тендерийн шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь хэсэг	ТӨӨЗ-ны 4.2.2 - Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байх шаардлагатай бөгөөд дараах тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойших хугацаанд авч ирүүлсэн байх шаардлагатай. Татварын өр, төлбөрийн талаарх лавлагааг www.tender.gov.mn цахим системийн Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татаж шалгана.	Цахим системээр дамжуулан тендер нээсэн өдөр буюу 2020 оны 06 дугаар сарын 21-ий өдрийн байдлаар татаж үзэхэд 41,250.00 төгрөгийн татварын өртэй байсан нь шаардлага хангахгүй.

3. “ИРМҮҮНБАР” ХХК дараах шаардлагыг хангаагүй гэж үзэж татгалзлаа.

№	Хуулийн үндэслэл	Тендерийн шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь хэсэг	ТӨӨЗ-ны 14.1 (ж) 2. Ажлын зургийн дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчинөөр баталгаажуулсан байна. ЗТХБХБ-ын сайдын 2012оны 01 сарын13- ны 18 тоот,2012 оны 181 -р тушаалуудаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу тооцсон байна./Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ/	Зураг төсвийг төсөв зохиох программаар гүйцэтгэж эрх бүхий төсөвчинөөр баталгаажуулан ирүүлээгүй нь шаардлага хангахгүй.
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь хэсэг	ТӨӨЗ-ны 14.1 (б) Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.	Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг ирүүлээгүй шаардлагад нийцэхгүй

4. “ТЭРГҮҮН КОНСТРАКШН” ХХК дараах шаардлагыг хангаагүй гэж үзэж татгалзлаа.

№	Хуулийн үндэслэл	Тендерийн шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дахь хэсэг	2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 2/3018 дугаартай албан бичгээр www.tender.gov.mn буюу худалдан авах ажиллагааны цахим системд инженер хайгуул зураг төслийн үнэ 32,035,071.00 төгрөгийг төсөвт тусган ирүүлэх тухай тодруулга оруулсан.	Төсөвт инженер хайгуул, зураг төслийн үнэ 32,035,071.00 төгрөгийг тусгаж ирүүлээгүй нь шаардлагад нийцэхгүй

	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь хэсэг	ТӨӨЗ-ны 5.3 (б) Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барилгын засварын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна. - Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, - Улсын комисс хүлээж авсан актын хуулбар, - Захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.	Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээ, комиссын акт захиалагч байгууллагын тодорхойлолт, ирүүлсэн боловч тус ажлын төсөвт өртгийн 80 хувьд хүрэхгүй байгаа нь шаардлага хангахгүй.
	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.1 дахь хэсэг	ТӨӨЗ-ны 5.3 (г) Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх. Үүнд: - Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны тодорхойлолтыг тендер нээхээс өмнө авна./ - Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт. /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн мэдэгдлийг үнэлгээнд харгалзахгүй./	Харилцагч банкны дансны үлдэгдэл болон зээл олгох тухай албан бичиг ирүүлээгүй нь шаардлагад нийцэхгүй.

5. “ЖИ ТИ КЭЙ ЭС” ХХК дараах шаардлагыг хангаагүй гэж үзэж татгалзлаа.

№	Хуулийн үндэслэл	Тендерийн шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дахь хэсэг	2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 2/3018 дугаартай албан бичгээр www.tender.gov.mn буюу худалдан авах ажиллагааны цахим системд инженер хайгуул зураг төслийн үнэ 32,035,071.00 төгрөгийг төсөвт тусган ирүүлэх тухай тодруулга оруулсан.	Төсөвт инженер хайгуул, зураг төслийн үнэ 32,035,071.00 төгрөгийг тусгаж ирүүлээгүй нь шаардлагад нийцэхгүй

6. “АКРОПОЛ” ХХК дараах шаардлагыг хангаагүй гэж үзэж татгалзлаа.

№	Хуулийн үндэслэл	Тендерийн шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар	-	“Акропол” ХХК –ийн ирүүлсэн тендер нь шаардлагад нийцсэн боловч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерт оролцогчдоос өндөр үнийн санал ирүүлсэн тул шаардлага хангахгүй.

	зүйлийн 28.7.3 дахь хэсэг	
--	---------------------------	--

9. ТЕНДЕРИЙГ НАРИЙВЧЛАН ХЯНАН ҮЗЭХ

“Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хийж гүйцэтгэхээр шаардлага хангасан тендер ирүүлсэн компаниудын ирүүлсэн тендерийн материалыг хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу үнэлгээг хийв.

9.1. АЛДАА ЗАЛРУУЛАХ

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1 дэх заалт, Тендерийн үнэлгээний зааврын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу хянан үзэхэд *арифметик алдаа илрээгүй болно.*

9.2 НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ БУЮУ ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙГ ТООЦОХ

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1 дэх заалт, Тендерийн үнэлгээний зааврын 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалт болон тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны холбогдох заалтын дагуу тус тус хянан үзэхэд үнийн хөнгөлөлт тооцохоор үнийн санал ирүүлээгүй болно.

9.3 ДОТООДЫН ДАВУУ ЭРХ ТООЦОХ

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах хүсэлт болон холбогдох нотлох баримтыг үндэслэн хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 58 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ыг мөрдлөгө болгон дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах саналыг шаардлага хангасан байгууллагаас ирүүлээгүй болно.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТЕНДЕРТ ДОТООДЫН ДАВУУ ЭРХ ОЛГОХ

N	Тендерт оролцогч	Давуу эрхийн үнэ ¹	Нийт үнэ ²	Давуу эрхэд хамрагдах ³	Өөрчлөгдсөн нийт ⁴	Давуу эрхийн үнэ ⁵	Давуу эрхийн зөрүү	Харьц уулах нийт үнэ
	(1)	(2)	(3)	(4)	(5)=(3)-(4)	(6)	(7)	(8)=(3)-(7)
1								

9.4. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЭЭС БАРАА ХУДАЛДАН АВАХ

Тухайн төсөл, арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад хамаарах бараа, бүтээгдэхүүний санал ирүүлээгүй болно.

10. ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДҮГНЭЛТ

Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/52 дугаар тушаалаар байгуулагдсан “Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийлээ.

¹ 2 дугаар баганад тендерт оролцогчийн санал болгож захиалагчийн нягтлан үзэж тогтоосон А /дотоодын тендерт оролцогч/ эсхүл Б /бусад тендерт оролцогч/ ангилал.

² 3 дугаар баганыг 11 дүгээр маягтын 6 дугаар баганаас авна. Хэрэв хамгийн бага нийт үнэ нь А ангилалын тендерт оролцогчийн үнэ байгаа бол тэр нь хамгийн сайн үнэлэгдсэн тендер болох ба энэ тохиолдолд хүснэгтийн үлдэх хэсгийг бөглөх шаардлагагүй.

³ 4 дүгээр баганад А ангиллын тендерийн 11 дүгээр маягтын 4, 5 дугаар баганы нийлбэр дүнг бичнэ. Энэ дүнг бүрдүүлж буй зардлын хэт өндөр дүнтэй хэсэгт тайлбар хавсаргана. 4, 5 дугаар баганыг А ангилалын тендерт оролцогчийн хувьд бөглөхгүй.

⁴ 7.5 хувь байна.

⁵ 7 дугаар баганад Б ангилалын тендерт оролцогчийн хувьд тэг (0), А ангилалын тендерт оролцогчийн хувьд 5 болон 6 дугаар баганы дүнгийн үржвэрийг бичнэ.

1. “Их-Азар” ХХК, “Ирмүүнбар” ХХК, “Тэргүүн констракшн” ХХК, “Жи Ти Кэй Эс” ХХК-иудын ирүүлсэн саналыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтыг үндэслэн үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн саналаар татгалзлаа.


2. “Зууны сод хийц” ХХК, “Акропол” ХХК-иудын ирүүлсэн санал нь шаардлагад нийцсэн боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3 дахь заалтын дагуу өндөр үнийн санал ирүүлсэн тул үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн саналаар татгалзлаа.

3. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3 дахь заалтын дагуу “шаардлагад нийцсэн бүх тендерийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж мөн хуулийн 28.7.4 дэх заалтад “хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно” гэж заасны дагуу “Бако констракшн” ХХК-ийн ирүүлсэн тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн гэж шийдвэрлэв.

Үнэлгээний хорооны дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:



Т.Хонгорзул, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

М.Гэрэлтуяа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөрөнгө оруулалтын эдийн засгийн тооцоолол, тайлагнал, бүртгэл их засварын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Х.Батчимэг, Санхүүгийн хэлтсийн Эрүүл мэндийн яамны төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Р.Дуламжав, “Нийгмийн хөгжлийн ертөнц” Төрийн бус байгууллагын гишүүн /зөвшилцсөнөөр/

О.Бат-Амгалан, “Судалгаа, Пиар мониторингийн стратеги академи” Төрийн бус байгууллагын менежер /зөвшилцсөнөөр/

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТОВЧ АГУУЛГА

1. Захиалагч	
1.1 Нэр	Эрүүл мэндийн яам
1.2 Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо , Олимпийн гудамж-2, 3Г-ын VIII байр,
2. Хөрөнгийн эх үүсвэр, батлагдсан шийдвэр	Монгол Улсын төсвийн тухай 2021 оны хууль, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 206 дугаар “Жагсаалт батлах тухай” тушаал
3. Төсөл хэрэгжих хугацаа /эх үүсвэр хүчинтэй байх хугацаа/	2021 он
4. Төслийн нэр, дугаар	“Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”
5. Гэрээний дугаар	ЭМЯ/2021.XII.2.3.12
6. Гэрээний нэр	“Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”
7. Гэрээний товч агуулга	Их засвар
8. Төсөвт өртөг	1 000 000 000 төгрөг
9. Гүйцэтгэгч сонгох ажиллагааны журам	Нээлттэй тендер шалгаруулалтын журам
10. Захиалагч эсхүл эрх бүхий байгууллагаар урьдчилан хянуулах шаардлагатай эсэх	Тендерийн баримт бичгийг боловсруулан захиалагчаар батлуулан тендерийг зарласан.
11. Дотоодын давуу эрхийн зөрүүг хэрэглэх	Тооцно
12. Тогтмол үнийн гэрээ	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.
13. Санхүүжилтийн бусад эх үүсвэр байгаа бол:	Байхгүй.
(1) Хамтран санхүүжүүлэгчийн нэр	
(2) Хамтран санхүүжүүлэх хувь	

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЯВЦ

1. Төслийг	
(а) анх баталсан огноо	2021 он
(б) хамгийн сүүлд өөрчилж баталсан огноо	2021 он
2. Урьдчилсан сонголт (шаардлагатай бол)	-
(а) урьдчилсан сонголтод тэнцсэн хуулийн этгээдийн тоо	-
(б) урьдчилсан сонголтын дүнг баталсан огноо	-
3. Урилгыг зарлаж мэдээлсэн	
(а) өдөр тутмын сонины нэр	Өнөөдөр сонин
(б) хэвлэгдсэн огноо	2021.05.21.
(в) бусад хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	www.tender.gov.mn
(г) олон улсын хэмжээний, эсхүл олон улсын хэл дээр хэвлэгддэг хэвлэл, мэдээллийн нэр	Үгүй
(д) хэвлэгдсэн огноо	Үгүй
(е) урилга илгээсэн этгээдийн тоо	Үгүй
(ё) урилга илгээсэн огноо	Үгүй
Тендерийн баримт бичиг	
(а) нэр, хэвлэсэн огноо	2021.05.21
(б) баталсан огноо	
(в) тендерт оролцогчдод тараасан хугацаа	2021.05.21
4. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан бол	Үгүй
(а) огноо (бүгдийг жагсаана уу)	
(б) баталсан огноо	-
3.1 Тендер шалгаруулалтын өмнөх уулзалт хийсэн бол, огноо	Үгүй
4.1 Тендер шалгаруулалтын өмнөх уулзалтын хийсэн бол тэмдэглэлийг тендерт оролцогчдод тараасан огноо	Үгүй

ТЕНДЕРИЙГ ХҮЛЭЭН АВАХ БОЛОН НЭЭХ

1. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	
(a) анхны огноо, цаг	2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 15 цаг 00 минут
(б) сунгасан огноо (хэрэв сунгасан бол)	Үгүй
2. Тендерийг нээх огноо, цаг	
(a) анхны огноо, цаг	2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 15 цаг 15 минут
(б) сунгасан огноо (хэрэв сунгасан бол)	Үгүй
3. Ирсэн тендерийн тоо	7
4. Тендер хүчинтэй байх хугацаа (хоногоор)	Тендер нээснээс хойш 30 хоног
(a) анхны тогтоосон хугацаа	2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр
(б) сунгасан хугацаа (хэрэв сунгасан бол)	-
(в) сунгалтыг үнэлгээний хорооноос баталсан огноо (шаардлагатай бол)	-

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ САНАЛ

1.Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогч (гэрээ байгуулах эрх олгох санал болгож буй).		
1.1 Нэр		
1.2 Хаяг		
2. Хэрэв тендер нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжсан бол жинхэнэ гүйцэтгэгчийн:	-	
2.1 Нэр	[нэр нөхөж бичих]	
2.2 Хаяг	[хаягийг нөхөж бичих]	
Түншлэл бол, гишүүн бүрийн нэр, улс, болон гэрээний гүйцэтгэлийг хариуцах хувийг жагсаах.	[түншлэлийн нэр, улс, болон гэрээний гүйцэтгэлийг хариуцах хувийг нөхөж бичих]	
	[түншлэлийн нэр, улс, болон гэрээний гүйцэтгэлийг хариуцах хувийг нөхөж бичих]	
	[түншлэлийн нэр, улс, болон гэрээний гүйцэтгэлийг хариуцах хувийг нөхөж бичих]	
Бараа/материалын гарал үүслийн улс	[улсын нэр нөхөж бичих]	
Гэрээнд гарын үсэг зурахаар тооцоолсон огноо (он, сар)	Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-с доошгүй хоногийн дараа гэрээ байгуулна.	
Бараа, ажил (хүргэж суурилуулах буюу гүйцэтгэх) дуусгах тооцоолсон хугацаа	[гэрээ тусгай нөхцөлөөс нөхөж бичих]	
Тендерийн зарлагдсан үнэ (тендерийг нээхэд зарлагдсан)	Төгрөг	Дүн эсхүл хувь /төгрөг/
		898,469,710.0
Алдааг залруулсан		
Үнийн хөнгөлөлт		-
Бусад тохируулга		-
Гэрээний санал болгосон үнэ		898,469,710.0

ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ

Төсөл арга хэмжээний нэр, дугаар: ЭМЯ/2021.ХИ.2.3.12 дугаартай "Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг"

№	Тендерт оролцогч	Эрх бүхий эсэх	Гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэх	Магадлах		Тендерийн баталгаа	Ажлын тоо хэмжээ бүрэн эсэх	Тендерийн баримт бичгийн үндсэн шаардлагыг хангасан эсэх	Шаардлагад нийцсэн тендер
				Тендерийн иж бүрдэл	Гарын үсэг зурах итгэмжлэл				
1	"Бако Констракшн" ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
2	"Зууны сод хийц" ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
3	"Их-Азар" ХХК	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй
4	"Ирмүүнбар" ХХК	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
5	"Тэргүүн констракшн" ХХК	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
6	"Жи Ти Кэй Эс" ХХК	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
7	"Акропол" ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

ГИШҮҮД:

 Т.ХОНГОРЗУЛ
 Х.БАТЧИМЭГ
 Р.ДУЛАМЖАВ
 О.БАТ-АМГАЛАН
 М.ГЭРЭЛТУЯА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

**“УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 50 ОРТОЙ БАЙРНЫ ЗАСВАР
УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ” ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛСЭН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр				
№	Аж ахуйн нэгжийн нэр	Хүлээн авч буй хүний нэр, албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг
1	“Бако Констракшн” ХХК	Г. Сувдмаа	91114006	Г. Сувдмаа
2	“Зууны сод хийц” ХХК	Майл. Ариунчим	2001150011118	
3	“Их-Азар” ХХК	Ариунчим	91445588	
4	“Ирмүүнбар” ХХК	С. Ариунчим	8811-9115	
5	“Тэргүүн констракшн” ХХК	Майл. Ариунчим	99079496	
6	“Жи Ти Кэй Эс” ХХК	Майл. Ариунчим		
7	“Акропол” ХХК	М. Ариунчим	88112674	

Хүлээлгэн өгсөн:



М.Гэрэлтуяа